



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1972 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 232

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн удирдлагын зохион байгуулалтад зарим өөрчлөлт оруулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

I. МАХН-ын ХҮИ их хурлын шийдвэр Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1972 оны 108 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр захиргааны аппаратын зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүнтэй холбогдсон бүх асуудлыг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн удирдлагын зохион байгуулалтад дор дурьдсан өөрчлөлтийг 1972 оны 7 дугаар сарын I-нээс эхлэн хийхээр тогтоосугай:

а/хөдөө аж ахуйн нэгдлийн төлөвлөлт, хөдөлмөр зохион байгуулалт, нормчлол, халс, бүртгэл, барилга, материал-техникийн хангамжийн асуудлыг Хөдөө аж ахуйн яаманд хариуцуулж, Нэгдлийн холбооны дээд зөвлөлийн ажил төрлийн ижил хэлтэс, группийг Хөдөө аж ахуйн яамны холбогдох хэлтэстэй нэгтгэсүгэй;

б/Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөл, аймгийн нэгдлийн зөвлөлд нэгдлийн эрх, ардчилал, нэгдлийн гишүүдийн тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөр хамгаалал, нэгдэл дундын амралт, рашаан сувиллын асуудлыг эрхлүүдсүгэй;

✓ в/сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, тэжээлийн үйлдвэр, үйлдвэрлэл-туршлагын станцыг аймаг, хотын гүйцэтгэх захиргаанд харъяалуулж, үржлийн болон үрийн сангийн аж ахуй,

2.

үйлдвэрлэл-туршлагын станцыг арга зүйн нэгдсэн удирдлагаар
Хөдөө аж ахуйн яам хангах байсугай;

✓ г/бүх аймгийн нэгдлийн зөвлөлийн эдийн засаг, үйлд-
вэрийн хэлтэс, Төв, Сэлэнгэ аймгийн сангийн аж ахуйн трес-
тийн үндсэн дээр нийт аймгийн гүйцэтгэх захиргаанд мал аж
ахуйн хэлтэс, газар тариалан, бэлчээр, тэжээлийн хэлтэс,
эдийн засгийн хэлтэс, боловсон хүчний хэлтэс бүхий хөдөө
аж ахуйг удирдах газар, Улаанбаатар хотын гүйцэтгэх захир-
гаанд хөдөө аж ахуйн хэлтэс байгуулсугай;

✓ д/аймгийн мал эмнэлгийн тасгийг одоогийн байгаа орон
тоо, цалинд өөрчлөлт оруулахгүйгээр аймгийн мал эмнэлгийн
газар болгосугай;

✓ е/аймгийн гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйг удирдах
газар байгуулж байгаатай холбогдуулан, Төв, Сэлэнгэ аймгийн
сангийн аж ахуйн трест, Дорнод аймгийн гүйцэтгэх захиргааны
сангийн аж ахуйн тасгийг татан буулгасугай.

2.Хөдөө аж ахуйн яамны зохион байгуулалтыг дор дурьдсан
газар,хэлтэс,алба, тасагтай байхаар өөрчлөн баталсугай:

а/мал эмнэлгийн газар /ариун цэврийн тасаг, амчлан
сэргийлэх тасаг, хяналт шалгалт-тоо бүртгэлийн тасагтай/;

б/мал аж ахуйн хэлтэс /үржлийн тасагтай/;

в/тэжээл,хадлан бэлчээрийн хэлтэс;

г/газар тариалангийн хэлтэс /үрийн тасагтай/;

д/механикжуулалтын хэлтэс;

е/газар зохион байгуулах хэлтэс;

ж/ургамал хамгаалал, хорно цээрийн улсын алба;

з/нэгдсэн төлөвлөгөөний хэлтэс;

и/санхүү, бүртгэлийн хэлтэс /бүртгэлийн тасагтай/;

3.

к/хөдөлмөр, цалин хөлсний хэлтэс /хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах лабораторитай/;

л/шинжлэх ухаан, арга зүйн секц;

м/шинжлэх ухаан, техникийн мэдээлэл, тэргүүн туршлага, суртал нэвтрүүлгийн секц;

н/гадаад харилцааны хэлтэс;

о/хөрөнгө оруулалт, барилгын хэлтэс;

п/нэгдэл дундын үйлдвэрийн хэлтэс;

р/боловсон хүчний хэлтэс;

с/иргэний хамгаалалтын тасаг;

т/шалгам зааварлах хэлтэс;

у/аж ахуйн хэлтэс.

3.Хөдөө аж ахуйн яамны орон тоог I дүгээр хавсралтын ёсоор 175 нэгжээр тогтоосугай.

4.Хөдөө аж ахуйн яаманд дор дурьдсан газрыг харъяалуулсугай:

а/хөдөө аж ахуйн материал-техникийн хамгамжийг удирдах газар;

б/мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори;

в/улсын үрийн төв лаборатори;

г/газар зохион байгуулах экспедиц;

д/хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн /нэгдсэн туршлага станц/;

е/хөдөө аж ахуйн дээд сургууль;

ж/хөдөө аж ахуйн техникум, техник мэргэжлийн сургууль, сургуулийн комбинат, байнгын курс;

з/хөдөө аж ахуйн экспедицэд үйлчлэх авто бааз;
 и/био-үйлдвэр;
 н/Хэрлэнбаян-улааны отор тэжээлийн станц;
 л/мал аж ахуйн экспедиц;
 м/мал эмнэлгийн шинжилгээний экспедиц;
 н/ургамал хамгаалал, хорио цээрийн төв лаборатори
 /станц/;
 о/барилгын захиалагчийн газар.

5.Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн зохион байгуулалтыг дор дурьдсан хэлтэстэй байхвар өөрчлөн баталсугай:

а/зохион зааварлах, эрхийн хэлтэс;
 б/хөдөлмөр хамгааллын хэлтэс;
 в/санхүү, тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс.

6.Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн орон тоог 2 дугаар хавсралтын ёсоор 14 нэгжээр тогтоосугай.

7.Аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйг удирдах газрын орон тоог 3 дугаар хавсралтын ёсоор 481 нэгжээр тогтоосугай.

8.Аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд дор дурьдсан байгууллагыг харъяалуулсугай:

а/сангийн аж ахуй;
 б/тэжээлийн аж ахуй, үйлдвэр, цех;
 в/хөдөө аж ахуйн нэгдэл;
 г/мал эмнэлгийн газар;

д/материал-техникийн хамгамжийн контор;

е/нэгдэл дундын үйлдвэр;

ж/үйлдвэрлэл-туршлагын станц;

з/үрийн лаборатори.

9. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйн хэлтсийн орон тоог хэлтсийн дарга I, мэргэжилтэн 4, ня-бо I, бүгд 6 нэгжээр тогтоож, тус хэлтэст шувуу фабрик, гахайн завод, Амгалангийн сангийн аж ахуй, хотын мал эмнэлэг, нэгдлийн захын конторыг харъяадуулсугай.

10. Сэлэнгээс бусад аймгийн нэгдлийн зөвлөлд зохион зааварлах, эрхийн хэлтэс ажиллуулсугай.

11. Хөдөө аж ахуйг удирдах газрын аж ахуй, санхүүг хариуцахтай холбогдуулан нийт аймгийн гүйцэтгэх захиргаадад бичээч, нягтлан бодогч тус бүр нэгний орон тоо нэмэгдүүлсугай.

12. Аймаг, хотын гүйцэтгэх захиргаадад үүрэг болгох нь:

а/аймгийн гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйг удирдах газрын ажлыг мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүний материал-техникийн баазыг бэхжүүлэх, машин техникийн ашиглалтыг сайжруулах, шинжлэх ухаан, техникийн ололт тэргүүний туршлагыг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, мал сүргийг элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэхэд чиглүүлсугай;

б/аймаг, хотын гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйг удирдах газар, хэлтсээр нэгдэл, хөдөө аж ахуйн улсын байгууллагын хэтийн болон жилийн төлөвлөгөө, тайлан балансыг үнэн зөв гаргуулан, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч байхыг хамт Хөдөө аж ахуйн яам, эдийн засгийн төв байгууллагуудад тогтоосон журмын дагуу өгүүлж байсугай;

6.

в/хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн бусад үйлдвэрийн газрын дотоод нөөцийг бүрэн ашиглан, ашигтай ажиллуулах арга хэмжээ авч ажилласугай.

13.Сангийн аж ахуй, тэхээлийн аж ахуй, улсын хөдөө аж ахуйн бусад байгууллагын удирдлага орон нутагт шилжиж байгаатай холбогдуулан, орон нутгийн өөрийн харъяа байгууллагаар дамжуулан тэдгээрийн бүх ажиллагааг санхүүхүүлж, урт богино хугацааны зээллэгээг олгох байхыг Улсын банкны ерөнхий хороо /н.ТӨМӨР/-д даалгасугай.

14.Хөдөө аж ахуйн удирдлагын зохион байгуулалтад зарим өөрчлөлт оруулсантай холбогдуулан, хөдөө аж ахуйн нэгдлийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд давхар хяналт шалгалт хийж байх үүргийг Сангийн яам /н.МОЛОМ/-д хариуцуулсугай.

15.Сангийн аж ахуй, тэхээлийн аж ахуй болон улсын хөдөө аж ахуйн бусад байгууллагын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт тавьж, шалгалтыг тогтмол хийж байхыг Сангийн яам /н.МОЛОМ/, Улсын банкны ерөнхий хороо /н.ТӨМӨР/-д даалгасугай.

16.Сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэлийг ашигтай ажиллуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг жил тутам тогтвортой дээшлүүлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын ба эдийн засгийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхийг Хөдөө аж ахуйн яам /н.ДАШ/-д даалгасугай.

17.Аймгийн нэгдлийн зөвлөл, сангийн аж ахуйн трестэд байсан хөдөө аж ахуйн хэрэгцээний суудлын автомашиныг шилжүүлэн авч, зөвхөн хөдөө аж ахуйг удирдах газрын ажлын хэрэгцээнд хэрэглүүлж байхыг нийт аймгийн гүйцэтгэх захиргаадад даалгасугай.

Үүнтэй холбогдуулан, аймгийн гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйн хэрэгцээнд суудлын автомашин хэрэглэх эрхийг дор дурьдсамаар нэмэгдүүлсүгэй;

7.

-Сэлэнгэд 1;

-Баян-өлгий, Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар тус бүр 3;

-Архангай, Баянхонгор, Говь-алтай, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтийд тус бүр 4;

-Төв аймагт 5.

18. Хөдөө аж ахуйн хэлтсийн албан ажлын хэрэгцээнд зориулан, Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дуудлагын суудлын автомашины эрхийг нэгээр нэмэгдүүлсүгэй.

19. Энэ тогтоол гарсантай холбогдуулан, Сайд нарын Зөвлөлийн дор дурьдсан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай:

а/"Хөдөө аж ахуйн яамны зохион байгуулалт, орон тооны тухай" 1970 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 79 дүгээр тогтоолын 1, 2, 3 дугаар зүйл;

б/"Хөдөө аж ахуйн яаманд орон тоо нэмэгдүүлэх тухай" 1971 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 47 дүгээр тогтоол;

в/"Хөдөө аж ахуйн яаманд тасаг байгуулах тухай" 1971 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 425 дугаар тогтоол;

г/"Ахлах мэргэжилтний орон тоо бий болгох тухай" 1971 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 177 дугаар тогтоол;

д/"Хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах тухай" 1971 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 259 дүгээр тогтоолын I дүгээр зүйл;

е/"Аюулаас хамгаалах тэжээлийн улсын фондын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1971 оны II дүгээр сарын 19-ний өдрийн 362 дугаар тогтоолын 8 дугаар зүйл;

8.

к/"Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн зохион байгуулалт, орон тоог батлах тухай" 1970 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 89 дүгээр тогтоолын 1.2 дугаар зүйл;

з/"Цөцгийн тос, эздэмцэр үйлдвэрлэх газрыг хөдөө аж ахуйн байгууллагад шилжүүлэх тухай" 1971 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 382 дугаар тогтоолын 9 дүгээр зүйл;

и/"Орон тоо нэмэгдүүлэх тухай" 1972 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 62 дугаар тогтоол;

к/"Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны байгууллагын зохион байгуулалт, орон тооны тухай" 1967 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 354 дүгээр тогтоолын 7 дугаар зүйл;

л/"Суудлын автомашин хэрэглэх эрх олгох тухай" 1970 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 188 дугаар тогтоол;

м/"Саягийн аж ахуйн трест байгуулах тухай" 1970 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоолын 1.2.4.5 дугаар зүйл, мөн 3 дугаар зүйлээс орон тоотой холбогдсон хэсэг.

БНМАУ-ын Сайд нарын
Зөвлөлийн дарга

Ю.ЦЭДЭНБАЛ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

Б.БАДАРЧ

Хуулоор үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч



/Ш.РИНЧИН/





Сайд нарийн Зөвлөлийн 1972 оны 232
дугаар тогтоолын I дүгээр хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ОРОН ТОО

1.Сайд	I
2.I дүгээр орлогч сайд	I
3.Орлогч сайд	5
4.Сайдын нарийн бичгийн дарга	I
5.Ерөнхий зоотехникч, ерөнхий их эмч, ерөнхий агрономч бөгөөд газар, хэлтсийн дарга	3
6.Хэлтсийн дарга, секцийн эрхлэгч, лабораторийн эрхлэгч	15
7.Алба, биеэ даасан тасгийн дарга	2
8.Хэлтэс дахь тасгийн дарга	5
9.Ерөнхий нягтлан бодогч	I
10.Орлогч нягтлан бодогч	I
11.Ахлах мэргэжилтэн	25
12.Малын их эмч, зоотехникч, инженер, эдийн засагч, агрономч, мэргэжил- тэн, мэргэжлийн байцаагч, заавар- лагч	89
13.Боловсон хүчний байцаагч	I
14.Барилгын техникч	2
15.Газар зохион байгуулагч-техникч	2
16.Парксийн техникч	I
17.Шифрлэгч холбоочин	I
18.Архив, нууцын эрхлэгч	I
19.Бичиг хэргийн эрхлэгч	I
20.Карт хөтлөгч	I
21.Ахлах бичээч бөгөөд олшруулагч	I
22.Бичээч	9 /хоёр нь гадаад хэлнийх/
23.Төсвийн ахлах нягтлан бодогч	I
24.Тооцооны нягтлан бодогч	2
25.Аж ахуйн нярав	I
26.Мөнгөний нярав	1
27.Олон улсын хөдөө аж ахуй сэтгүүлийн редактор	I



Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 232
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДЛИЙН ХОЛБООНЫ ДЭЭД
ЗӨВЛӨЛИЙН ОРОН ТОО**

Албан тушаал	Орон тоо
1. Орлогч дарга	I
2. Хэлтсийн дарга	3
3. Ахлах мэргэжилтэн	2
4. Мэргэжилтэн	5
5. Нягтлан бодогч	I
6. Бичээч, олшруулагч	I
7. Архивын эрхлэгч бөгөөд нарийн бичгийн дарга	I
ДҮН	I4



Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 232
дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХӨДӨӨ АЖ
АХУЙГ УДИРДАХ ГАЗРЫН ОРОН ТОО

	Орлогч дарга	Хэлтсийн дарга	Тасгийн дарга	Ахлах инженер, ах- лах байцаагч	Эдийн засагч, инженер, зоотехникч бусад мэр- гэжилтэн	Байцаагч, зааварлагч, байцаагч нягтлан бо- догч, ахлах нягтлан бодогч	Газар зохион бай- гуулагч	Барилгын техникч, тоо- цооны нягтлан бодогч, тоо бүртгэгч, шинжил- гээний лаборант	БҮГД
1.Архангай	1	3	1	1	9	10	1	4	30
2.Баянхонгор	1	3	1	1	9	8	1	4	28
3.Баян-өлгий	1	3	1	1	8	6	1	4	25
4.Булган	1	3	1	1	9	8	1	4	28
5.Говь-алтай	1	3	1	-	8	6	1	2	22
6.Дорноговь	1	3	1	-	8	5	1	2	21
7.Дорнод	1	3	1	1	9	5	1	4	25
8.Дундговь	1	3	1	-	8	5	1	2	21
9.Завхан	1	3	1	1	9	10	1	4	30
10.Өвөрхангай	1	3	1	1	9	8	1	4	28
11.Өмнөговь	1	3	1	-	8	5	1	2	21
12.Сүхбаатар	1	3	1	1	8	5	1	4	24
13.Төв	2	3	1	2	14	10	1	5	38
14.Увс	1	3	1	1	9	7	1	4	27
15.Ховд	1	3	1	1	8	8	1	4	27
16.Хөвсгөл	1	3	1	1	10	11	1	4	32
17.Хэнтий	1	3	1	1	10	7	1	4	28
18.Сэлэнгэ	1	3	1	1	11	5	1	3	26
ДҮН	19	54	18	15	164	129	18	64	481